



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИГЧ МИШИГДОРЖИЙН  
ГАНЗОРИГ ТАНАА**

2024.09.03 № ГНАГ-2024/13-УТА-НА-104  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Мишигдоржийн Ганзоригийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн

- 018021097

төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Мишигдоржийн Ганзориг /РД:ME72020810/-ийн Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Мишигдоржийн Ганзоригийн мөрийн хөтөлбөр ( 2 хуудас )-ийг хавсаргав.


Хувийг: Хүдэр сумын сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ МИШИГДОРЖИЙН ГАНЗОРИГИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**1. Боловсролын чиглэлээр:**

- 1.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, хувь хүний хөгжил, гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.
- 1.2. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.

**2. Эрүүл мэндийн чиглэлээр:**

- 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг сайжруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллана.
- 2.2. Дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэх аян өрнүүлж, өвчлөлийн тоог бууруулна.

**3. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр:**

- 3.1. Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, иргэдийн өрхийн амьжиргааг дэмжих талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.2. Тогтвортой ажлын байр бий болгож, иргэдийг ажлын байраар хангаж байгаа иргэн, ААН-ийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

**4. ХАА-н чиглэлээр:**

- 4.1. Сум орон нутгийн малчдад тулгамдсан нийтлэг асуудлыг шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан хамтран хэрэгжүүлнэ.
- 4.2. Сум орон нутагт өрхийн үйлдвэрлэл эрхэлж, хүнсний ногоо тарьж, ургуулж байгаа иргэд, ногоочдын холбооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, хамтарч ажиллана.

**5. Байгаль орчны чиглэлээр:**

- 5.1. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.



5.2. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.

**6. Төрийн захиргааны чиглэлээр:**

- 6.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 6.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийг камержуулж, суманд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

